

ЛЕКЦ, ЯРИАНЫ СЭДЭВ

Д. Цагаан

ХЯТАДЫН ДОТООД БАЙДАЛ

Сүүлийн үед Хятадад болж байгаа хэрэг явдлуудаас үзвэл маоизм улс төр, эдийн засаг, үзэл суртал, ёс суртахууны хувьд улам гүнзгий хямралд орж байгаа нь илэрхий болж байна.

БНХАУ-ын улс төрийн байдал нь хямралтай хэвээр байгаа нь Линь Бяо ба «дөрвийн бүлгийнхнийг хувьсгалын эсэргүү этгээдүүд хэмээн шийтгэж,¹ Хуа Гофэнийг төрийн талын албан тушаалаас нь шахан зайлуулж хятадын эрх баригчид одоо хүртэл засгийн эрхийн төлөө үргэлжлэн тэмцэлдэж байгаагаас тодорхой байна. 1969 онд хуралдсан Хятадын Коммунист Намын IX их хурлаас маршал Линь Бяог Маогийн залгамжлагчаар баталсан тухай албан ёсоор зарласан билээ. Маогийн бэлбэсэн гэргий Зян Цин тэргүүтэй «дөрвийн бүлэг» гэгч нь «соёлын хувьсгалын» үед (1966-1976) Маогийн шадар туслагч, ХКН-ын Төв Хорооны гол хариуцлагатан нар гэгдэж байв. Гэтэл Бээжингийн өнөөгийн эрх баригчдаас «дөрвийн бүлэг» хэмээн шийтгэж буй эдгээр хүмүүс нь Мао Зэдунд үнэнч үйлчилж түүний заавраар Хятадын эгэл жирийн ард түмэн, коммунистуудыг хороохоос эхлээд нам, төрийн байгууллагуудыг бусниулах зэрэг бүхий л хорлон сүйтгэх ажилд идэвхтэй оролцож байжээ. Хуа Гофэн бол Маогийн «гэрээсээр» ХКН-ын Төв Хорооны даргын албан тушаалд дэвшин ажилласан болох нь нийтэд тодорхой билээ. Өнөөгийн хятадын эрх баригч бүлгийн дотоод тэмцэлд үндсэндээ Маогийн талынхныг нам, төрийн эрх тушаалаас аль болохоор шахан зайлуулах, нам, төрийн эрх мэдлийг дахин хуваарилах гэсэн хоёр чиглэлд явагдаж байна. Одоогийн байдлаар Дэн Сяопин тэргүүтэй бүлэглэлийн хүч давамгайлах төлөвтэй болж байгаа энэ тэмцэл нь хэрэг дээрээ 1977 оны 7-р сард Дэн Сяопин Хятадын улс төрийн тавцанд дахин гарч ирсэн тэр үеэс нэгэнт эхэлсэн ажээ. Тэрээр хятадын улс төрийн тавцанд гарч ирсэн цагаасаа эхлэн өөрийн байр сууриа бэхжүүлэх талын ажлыг шат дараалан хийж, нам, төр, цэргийн өндөр тушаалын албыг хүлээн авсан юм. Түүнээс гадна Дэн Сяопин өөрийн талын хүмүүсийг ээлж дараалан зохих албан тушаалд татан ажиллуулж, ялангуяа ХКН-ын Төв Хорооны бүрэлдүүнд цааш нь улс төрийн товчооны албан тушаалд тавьж ажиллуулах ажлыг идэвхтэй шуурхайлан хийсэн билээ. 1977 оны 8-р сард хуралдсан ХКН-ын XI хурлаас хойш Дэнгийн талын хүч нөлөө, байр суурь үзэгдэхүйц бэхжиж, дараа оны 11-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны III бүгд хурал дээр Дэн Сяопин, Ху Яобаны бүлэг албан ёсоор бүрэлдэж, Хуа Гофэний талын эрх мэдэл эрс сулрав. 1980 оны 2-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны V бүгд хурлаар Лю Шаоцийг цагаатгаж, түүний зургийг сонин хэвлэлд тавьж, Маогийн хөргийг энд тэндгүй татан буулгасан нь «соёлын хувьсгалыг» үндсээр нь үгүйсгэж, Маог буруушааж байгаагийн шинж тэмдэг болов. ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны байнгын хорооны гишүүн Ли Сяньнянь 1978 оны 7-р сард америкийн хэвлэлийнхэн-

¹ХКН-ын IX их хурлаар сонгогдсон Төв Хорооны улс төрийн товчооны 9 гишүүн шийтгүүлжээ.

тэй ярилцахдаа «соёлын хувьсгал» бол гай гамшиг, «үсрэнгүй давшилт» бол хэнээрхэл, Линь Бяо болон «дөрвийн бүлгийг дэвшүүлэн гаргасан нь том алдаа гэх мэтээр шүүмжилсэн байна. Дэн Сяопин ба түүний талынхны Маог тийнхүү тойруу замаар шүүмжилж эхэлж байгаа боловч одоохондоо Мао Зэдуныг хамгаалсан хэвээр байна. Социализм, коммунизмын эсрэг Мао Зэдуны харгис үзэл суртал, их хан үндэстний дээрэнгүй жанжлах бодлого нь Хятадын өнөөгийн удирдлагын гадаад бодлогод хэрэг болно гэж үзэж байна. Тийм ч учраас тэд «Мао Зэдуны үзэл санааны жинхэнэ нүүр царайг нь сэргээе» гэж уриалсаар байна. Энэ нь Маогийн «үзэл санаа» гэгчээр Хятадын өнөөгийн удирдагчид өөрсдийн харгис нүүр царайг халхавчлахыг оролдож байгаа хэрэг даруй мөн.

Ер нь ХКН ажилчин айгийн жинхэнэ манлайлалын үүрэг гүйцэтгэж чадахаа болиод удаж байгаа бөгөөд одоо ч хэвээр байна. Энэ байдлыг бээжингийн удирдагчид хүлээн зөвшөөрч байна. 1980 оны 1 сарын 16-нд болсон удирдах ажилтны зөвлөлгөөн дээр Дэн Сяопин тавьсан илтгэлдээ хэлсэн зарим зүйлээс жишээ болгон авъя. «Намын нэр хүнд одоо урьдынхтайгаа адилгүй болсон гэдгийг тэмдэглүүштэй байна. ...20 гаруй сая ажилчдыг хөдөө орон нутагт илгээж, яагаад тэгэх болсны учрыг намын бодлогын дагуу тодорхой тайлбарласан, тэгээд ганц ч хүн гомдол гаргаагүй байсан тэр үеийг эргэн санахад илүүдэхгүй» гэж хэлээд «одоо тийм ажил зохионо гэхэд тийм хялбар бишээ» гэжээ. ХКН-ын гишүүдийн зарим хэсэг нь ялангуяа залуу шинэ гишүүд маоизмын хэт зүүний лоозонд автаж, олон түмэнд үлгэр дууриал болохоосоо тэднийг элдэв муухай зүйлд уруу татах тал нь дийлж байна. Тэр ч байтугай ахмад гишүүд нь улс төр, ёс суртахууны хувьд ялзарч байна.* Энэ тухай Дэн Сяопин дээр дурдсан илтгэлдээ хүлээхээс өөр аргагүй болжээ. Нэг үгээр хэлэхэд намын сахилга бат бүх талаар алдагдсан учир Дэн Сяопины хэлдгээр нам удирдах ролио гүйцэтгэж чадахаа больсон байна.

Эдийн засгийн хувьд хятад орон улам хүнд бөгөөд зөрчилтэй байдалд ороод байна. Дэн Сяопин дээрх илтгэлдээ хэлснээр Хятад орон «өнгөрсөн 30 жилд элдвийн донсолгооноос болж эдийн засгийн бүтээн байгуулалтанд ажлаа төвлөрүүлж чадаагүй. Учир иймд социализмын давуу талыг туйлын бага ашиглаж нийгмийн үйлдвэрлэх хүчин маш удаан хөгжжээ». 36 жилд хятад орон маоизмын эдийн засгийн адал балмад бодлогын туршлагын талбай болж иржээ. Тэгвэл Хятадын өнөөгийн удирдлагын авч явуулж байгаа эдийн засгийн арга хэмжээ нь дээрх алдагдлыг нөхөх нь бүү хэл, Хятад дахь социалист эдийн засгийн үндсийг бүрмөсөн устгахад чиглэж байна. Одоо Хятадын эдийн засаг нь улсынх, гадаадын капиталтай хувь нийлүүлсэн бэлэн хувийн гэсэи гурван хэсгээс бүрэлдэж байна. Хятадын эрх баригчид хувь хүний хөрөнгөөр салбар үйлдвэрүүдийг байгуулж улсын үйлдвэрүүдэд харъяалуулах замаар улсын секторын зарим үйлдвэрүүдийг алба-амины хувь нийлүүлсэн аж ахуй болгохыг сэдэж байна.

Гадаадын капиталд газар түрээслэх, талбай ба түрээсний хэмжээ, хугацааг тогтоохдоо олон талын хөнгөлөлт үзүүлж байна. Гадаадын үйлдвэр аж ахуйн газрын эзэд, албан хаагчид ашиг орлогын татварын 15 хувийг төлчихвөл ашиг, хүү, цалингаа өөр орон руу гуйвуулах эрхтэй ажээ.** Гадаадын капиталтай хамтран ажиллахын тулд эдийн засгийн тусгай районуудыг байгуулж байна. Тэдгээрийн нилээд нь хятадын нутагт бай-

*хээл хахуул авах, эрх тушаалаа ашиглаж улсын хөрөнгийг идэж ашиглах явдал хавтгайрч газар авч байна.

**Хятадад ардын хувьсгал ялсны эхний жилүүдэд гадаадын капиталыг бүрэн шахан зайлуулсан юм.

гаа Английн колони Гонконгийн зах зээл, тээвэр, банк, даатгалын компанийг түшиглэх ажээ.

Одоогийн байдлаар Хятадад 400 гаруй мянган хувийн үйлдвэр, аж ахуй бий болоод байна. Гэтэл «ашиггүй» гэсэн нэрийдлээр олон тооны улсын үйлдвэрүүдийг татан буулгаж байна. Хятадын эрх баригчид энэ бүгдийг хийхдээ социализмын төлөвлөлтийг «хүнд суртал» мэтээр гүтгэн дайрч капитализмын зах зээлээр зохицуулахыг ашигтай гэж үзэж байна. Тэгвэл энэ нь Хятадад тоо бүртгэл, тайлан тооцоогүй болсоор олон жил болж байгаа тул улс ардын аж ахуйг төлөвлөх тэнхэл чадваргүй болсноо Бээжингийн эрх баригчид ард түмнээсээ нууж байгаа хэрэг юм.

Одоо Хятадад эдийн засгийн гол зорилт болж байгаа «дөрвөн шинэчлэлт» гэдэг нь ойрын ба хэтийн төлөвлөөгүй, энэ зууны эцэст Хятад орныг «хүчирхэг гүрэн» болгоно гэсэн мухар сохор лоозон л явж байна. «Дөрвөн шинэчлэлтийг» хэрэгжүүлэхийн тулд капитализмаас их зүйл сурахыг хичээж, үйлдвэрлэлийг зохион байгуулах капиталист арга туршлагыг хэвлэлээр дамжуулан сурталчилж байгаагаас гадна дотооддоо тусгай курсээр «боловсон хүчин» бэлдэж өрнөдийн гүрнүүд болон Япон улсад олон мянган хүнийг сургаж байна.

Санхүүгийн талаар үлэмж бэрхшээлд учирч байна. Улсын нэгдсэн төлөвлөгөө байхгүй учир хөрөнгө оруулалт түүний гүйцэтгэлд ямарч хяналт байхгүй. Төсвөөс гадуур хөрөнгө мөнгийг дур зоргоороо зарцуулж байна. Иймд төсөвт объектуудыг барьж байгуулах ажлыг зогсоох буюу хойшлуулахад хүрч байна. Зөвхөн Жэзян муж гэхэд 1930 онд барилгын 93 объектыг зогсоосон буюу хойшлуулжээ. Хөрөнгө оруулалтыг нь 620 сая юаниар хорогдуулжээ. Зөвхөн энэ мужид төсвөөс гадуур барьж байгуулж байгаа зүйлд зарцуулсан хөрөнгө нь бүх хөрөнгө оруулалтын 43 хувьтай тэнцэж байна. Учир иймд улсын төсвийн алдагдал жилээс жилд нэмэгдэж байна. 1979 оны улсын төсвийн гүйцэтгэлээс үзвэл 17 мил- лиард юаний алдагдалтай байсан бол 1980 онд 19,2 миллиард юанд хүрсэн байна. Гэвч цэргийн зардал жилээс жилд нэмэгдэж байна. Эдийн засагчдын тооцоолсноор БНХАУ-ын анхдугаар (1953-1957) таван жилийн хугацаанд нийгэм соёлын зардлын коэффициентын өсөлт нь цэргийн зардлынхаас 1,6 дахинаар түрүүлж байсан бол сүүлийн 20 жилд цэргийн зардлын коэффициентын өсөлт нь нийгэм-соёлын зардлынхаасаа 1.25 дахин хурдан болсон байна. Бээжингийн өнөөгийн дэглэмийг орчин үеийн дайн хийх иж бүрэн зэвсгээр хангахад 41-60 миллиард доллар шаардагдах ба үүнийг хангаснаар зэвсгийн үйлдвэрийн монополистуудад асар их ашиг орно гэсэн тооцоог Вашингтонд гаргасан байна.

Хятадын улс ардын аж ахуй ихээхэн алдагдалтай байгаагийн бас нэг шалтгаан гэвэл гадаадаас өндөр боловсронгуй тоног төхөөрөмжөөр хангагдсан үйлдвэрийг эмх замбараагүй авч байгаад оршиж байна. Жишээлбэл: Уханий металлургийн комбинатад японы «Синнити тэцу» фирмийн тусламжаар халуун аргаар металлыг дарж сунгах үйлдвэр байгуулжээ. Гэтэл ашиглалтанд орсон хойноо цахилгаан эрчим хүч хангалтгүйгээс болж жилдээ 3 сая тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс дөнгөж 600 мянган тонн үйлдвэрлэж байна. Мөн Сиань хотод Швейцарийн нарийн тоногоор төхөөрөмжилсөн цагны үйлдвэр байгуулжээ. Инженер, техник, ажилчдын мэргэжил доройгоос болж 2,4 сая ширхэг цаг үйлдвэрлэх чадалтай боловч дөнгөж 600 мянган ширхэг үйлдвэрлэж байгаагаас 37 хувь нь гологдол болж байна.

Ард түмний аж байдлыг дээшлүүлэх лоозонг сүүлийн үед дэвшүүлж байна. Хятадын хүн амын 80 гаруй хувь нь тариачид юм. Эрт дээр үеэс хятад оронд тариачны аж байдал хамгийн ядуу байсан ба одоо ч хэ-

вээр байна. 1980 онд хятадын хэвлэлд мэдээлснээр үзвэл ардын коммуны 1692 их бригадын хүн бүрийн жилийн дундаж орлого 300 юаниас (1110 орчим төгрөг) давсан ажээ. Гэтэл энэ нь хятад улсын хэмжээний бүх их бригадын дөнгөж 2,3 хувийг эзэлж байна. Одоогийн байдлаар хятадын хүн ам тутамын өдрийн орлого 2,2 фэнь буюу 0,8 төгрөгтэй тэнцэж байна. Мөнгөний ханш буурч, барааны үнэ байнга нэмэгдэж байна. Томоохон хотуудад өргөн хэрэгцээний барааны үнэ жилд 10-12 хувиар нэмэгдэж байна. Ардын боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалахад улсаас тун ч бага хөрөнгө гаргаж байна. Иймд хятадын нийт хүн амын аж байдлын түвшин маш дорой байна. Үүнийг Дэн Сяопин дээр дурдсан илтгэлдээ бас хүлээн зөвшөөрчөө. ХКН-ын Төв Хорооны орлогч дарга Ли Сяньняны ярьснаар бол одоо хятадад 100 гаруй сая хүн байнгын өлсгөлөнд нэрвэгдэж байна. Барааны үнийг тогтвортой болгох, аж байдлыг дээшлүүлэх тодорхой арга хэмжээ авахыг шаардаж олон нийтийн жагсаал хятадын хотуудад болж байна. Нийгмийн өвчин болж хувирсан хэд хэдэн асуудал улам ноцтой болж байна. Зарим өндөр албан тушаалтан төдийгүй, бүх шатны олон салбарын удирдах ажилтнууд онцгой эрх эдлэхийн хойноос хөөцөлдөж байна. «Товчоор хэлбэл манай зарим ажилтан түшмэл болон хувираад амирлангуй болов» гэж Дэн Сяопин хэлжээ. Хятадын нам улсын байгууллага, үйлдвэр аж ахуйн газарт хүнд суртал ноёрхож, Дэнгийн хэлснээр «утсаар нэг яриад шийдчих асуудлыг хагас жил хойш тавьж, өдөржингөө хурал цуглаан хийж» цаг өнгөрөөж байна.

ХКН БНХАУ-ыг удирдан зохион байгуулахдаа социализмын давуу талыг ашиглаж чадаагүйн гол учир гэвэл «Мао Зэдуны үзэл санаа» гэгч жижиг хөрөнгөтний адал балмад чиг шугамаар марксизм-ленинизмыг орлуулсны уршиг юм. «Мао Зэдуны үзэл санааны жинхэнэ нүүр царайг сэргээх» тухай хятадын суртал нэвтрүүлэг сүүлийн үед олонтоо бичиж байна. Тэр «үзэл санаа» сэргэвэл хятад орон, хятадын ард түмэнд өнгөрсөн 30 жилд тохиолдсон гай зовлон шиг золгүй явдал, магадгүй түүнээс ч илүү хор уршигтай явдал тохиолдох юм.

Энэ сэдэвтэй холбогдуулан «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлийн 1980 оны дугаар 1981 оны № 1, «Проблемы Дальнего Востока» сэтгүүлийн 1980 оны №-3, «Коммунист» сэтгүүлийн 1980 оны № 17, «Нозое время» сэтгүүлийн 1980 оны №-33, 1981 оны № 2 ыг уншина уу.